



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2012 оны 07 сарын 16 өдөр

Дугаар 261

Улаанбаатар хот

Г Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн
дүрэм, бүтцийг батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24.1.4 дэх заалтыг үндэслэн
ТУШААХ нь:


1. Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн дүрмийг нэгдүгээр, бүтцийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Бүтцийн өөрчлөлттэй холбоотой шаардагдах хөрөнгийг 2013 оны төсөвт тусган санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Санхүү, хөрөнгө оруулалтын газар (Д.Отгонбаатар), төвийн үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Эмнэлгийн тусlamжийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (Д.Гончигсүрэн)-т тус тус даалгасугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга Н.Түмэндэмбэрэлд үүрэг болгосугай.
4. Энэхүү тушаал гарсантай холбоотойгоор Эрүүл мэндийн сайдын 2007 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 138 тоот тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



Н.ХҮРЭЛБААТАР

060346



226

Эрүүл мэндийн сайдын
2012 оны 7. сарын 16. өдрийн
261 дугаар нэгдүгээр хавсралт

ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Цус сэлбэлт судлалын үндэсний төв нь (цаашид "Төв" гэх) Монгол Улсын төрөөс донорын цус, цусан бүтээгдэхүүний хангамжийг сайжруулах, аюулгүй байдлыг хангах талаар төрөөс баримтлах бодлого, хөтөлбөр, хууль, тогтоомж, тушаал, зааврыг хэрэгжүүлэх, хэрэгжилтэнд хяналт тавих, аймаг сумдын цусны салбар төвүүдийн үйл ажиллагааг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, сургалт, эрдэм шинжилгээ, судалгаа явуулах эрүүл мэндийн мэргэжлийн байгууллага мөн;

1.2. Төвийн зорилго нь үйлчлүүлэгчийн хэрэгцээ шаардлагыг хангасан аюулгүй, эмчилгээний өндөр идэвх бүхий цус, цусан бүтээгдэхүүнээр эрүүл мэндийн байгууллагуудыг хангах, улсын хэмжээнд цусны албаны бодлогыг хэрэгжүүлэх, салбар албадыг мэргэжлийн удирдлагаар хангах явдал юм;

1.3. Төв нь үйл ажиллагаандaa хууль тогтоомж, энэхүү дүрэм болон тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журмыг баримтална;

1.4. Төв нь тогтоосон журмын дагуу үйлдсэн тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

Хоёр. Төвийн чиг үүрэг

Төв нь дор дурьдсан чиг үүргийг хүлээнэ.

2.1. Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэр, үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн зорилтыг өөрийн үйл ажиллагааныхаа хүрээнд хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийг хангах;

2.2. Байгууллагынхаа боловсон хүчний хэрэгцээг тодорхойлж, тэднийг бэлтгэх, давтан сургах, мэргэшлийг нь дээшлүүлэх, дахин мэргэшүүлэх ажлыг зохион байгуулах, ажиллагчдын хөдөлмөрийн хэвийн нөхцөл, нийгмийн баталгааг хангахтай холбогдсон арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

2.3. Үйл ажиллагааныхаа хүрээнд төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах;

- 2.4. Хууль тогтоомжид нийцүүлэн үйл ажиллагаандаа дагаж мөрдөх заавар, дүрэм, журам боловсруулж мөрдүүлэх, биелэлтэд нь хяналт тавьж, илэрсэн гажуудал, дутагдлыг арилгах;
- 2.5. Үйл ажиллагааных нь чиглэлээр гаргасан иргэдийн санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх;
- 2.6. Хууль тогтоомж, байгууллагын дүрэм, дотоод журмыг зөрчсөн албан тушаалтанд хуулиар олгогдсон эрх хэмжээний хүрээнд хариуцлага хүлээлгэх;
- 2.7. Байгууллагын эзэмшилд байгаа төрийн өмчийг зохистой ашиглах, ашиглалтын байдалд хяналт тавих, хадгалах, хамгаалах зохицуулах арга хэмжээ авах;
- 2.8. Байгууллагын үйл ажиллагааны болон хэтийн төлөвлөгөөг боловсруулах, чиг үүрэгт хамаарах асуудлаар гадаад орнуудын ижил төрлийн болон олон улсын холбогдох байгууллага, хүмүүстэй хууль тогтоомжоор олгосон эрх хэмжээний хүрээнд хамтран ажиллах гэрээ, хэлэлцээр байгуулан хэрэгжүүлэх.

Гурав. Төвийн удирдлага, зохион байгуулалт

- 3.1. Төв нь Эрүүл мэндийн тухай хуулийн 17.7-д заасан чиг үүрэг бүхий Удирдах зөвлөлтэй байна;
- 3.2. Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална;
- 3.3. Төвийн захирлыг Удирдах зөвлөлийн саналыг харгалzan эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн томилж, чөлөөлнө;
- 3.4. Төв нь тусlamж, үйлчилгээ болон стратеги төлөвлөлт, сургалт, судалгаа эрхэлсэн дэд захиралтай байх бөгөөд Удирдах зөвлөлтэй зөвшилцэн төвийн захирал томилж, чөлөөлнө;
- 3.5. Захирал нь эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй үр дүнгийн гэрээ байгуулан ажиллаж төвийн зорилт, чиг үргийг хэрэгжүүлэх ажлыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн болон Удирдах зөвлөлийн өмнө бүрэн хариуцаж тайлagnана;
- 3.6. Төвийн зохион байгуулалтын бүтэц, орон тоог эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцэн захирал батална;

3.7. Төв нь захирлын ажлын, чанарын, стратеги төлөвлөлтийн, донор элсүүлэх, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн, нэгдсэн лабораторийн, сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны, санхүү хангамж үйлчилгээний албуудтай байна;

3.8 Төв нь аюулгүй цус цусан бүтээгдэхүүнээр үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай багаж, тоног төхөөрөмж, эмнэлгийн хэрэгсэл, урвалж оношлуур, зориулалтын байраар хангагдсан байна;

3.9. Захирал нь өөрийн улсын болон гадаадын ижил түвшний байгууллага, аж ахуйн нэгж, иргэнтэй харилцах, гэрээ байгуулах, хэлцэл хийх, ажилтанг ажилд авах, ажлаас чөлөөлөх, шагнаж урамшуулах, тэдэнд хөдөлмөрийн хуульд заасны дагуу сахилгын шийтгэл ноогдуулна;

3.10. Төвийн бүтцэд ажиллах алба, тасаг, лаборатори, үйлдвэрлэлийн дарга, эрхлэгч нь өөрийн үйл ажиллагааны чиглэлээр хийх ажлын төлөвлөгөөг боловсруулан төвийн захирлаар батлуулан, биелэлтийг захирал, дэд захирлын өмнө шууд хариуцна;

3.11. Төвийн лабораториуд өөрийн хариуцсан чиглэлээр олон улсын лабораторийн итгэмжлэлийн ISO 9001, ISO 15189 стандартын дагуу үйл ажиллагаа явуулна;

3.12. Төв нь зөвлөх эрх бүхий 15 хүртэлх хүний бүрэлдэхүүнтэй Эрдмийн зөвлөлтэй байх бөгөөд үйл ажиллагааны журам, бүрэлдэхүүнийг нь захирлын тушаалаар батална.

Дөрөв. Төвийн эрх, үүрэг

4.1. Байгууллага нь дор дурдсан үүрэг хүлээнэ:

4.1.1. Эрүүл мэндийн тухай хуульд заасан эрүүл мэндийн байгууллагын нийтлэг үүргийг биелүүлэх;

4.1.2. Батлагдсан шалгуур үзүүлэлтийн дагуу сайн дурын авлагагүй донороос цус, сийвэн, эс цуглуулах;

4.1.3. Эмнэлгүүдийн захиалгат цус, цусан бүтээгдэхүүнийг стандартын дагуу үйлдвэрлэх, хадгалах, олгох;

4.1.4. Трансфузиологийн лавлагаа лабораторийг хөгжүүлэн улсын хэмжээнд чанарын баталгаажилтыг хариуцан гүйцэтгэх;

4.1.5. Улсын хэмжээнд цусны албаны үйл ажиллагаа, цус, цусан бүтээгдэхүүний стандарт, аргачлалыг боловсруулан батлуулах, хэрэгжилтэнд хяналт тавих;

4.1.6. Цусны аюулгүй байдлыг хангахтай холбоотой гарсан хууль, тогтоол, тушаал шийдвэрийг хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих, үнэлгээ хийх, зөвлөмжөөр хангах;

4.1.7. Цусны хүүдий, оношуур /ХДХВ, В, С гепатит, тэмбүү, цусны бүлгүүд, цус бүлэгнүүлэх факторын идэвхи тодорхойлох/, болон эмчилгээний зориулалт бүхий цусны бэлдмэлүүдээр /альбумин, VIII, IX фактор, эритропоэтин, перфторан/ цусны салбар төвүүдийг хангах;

4.1.8. Эрүүл мэндийн байгууллагуудын цус, цусны бүтээгдэхүүний зохистой хэрэглээг бий болгох чиглэлээр эмнэлгүүдийн Цус сэлбэлтийг зохицуулах зөвлөлтэй хамтран ажиллах;

4.1.9. Цуглуулсан цус, сийвэн, эсийн нэгж бүрд болон үйлдвэрлэсэн цус, цусан бүтээгдэхүүний дээжинд чанарын шинжилгээг зохих стандартын дагуу чанарын баталгаатай хийх.

4.2. Байгууллага нь дор дурдсан эрх эдэлнэ:

4.2.1. Монгол Улсын хэмжээнд цус, цусан бүтээгдэхүүний хангамжийг сайжруулж, аюулгүй байдлыг хангах чиглэлээр хууль, тогтоол, хөтөлбөр, стандарт, төсөл боловсруулахад тэргүүлэн оролцох, албан ёсоор санал, дүгнэлт гаргах, энэ чиглэлээр улсын хэмжээнд мөрдөгдөх хууль дүрэм, стандарт, технологийн заавар, судалгааны ажлын аргачлал боловсруулах;

4.2.2. Цусны албаны чиглэлээр дотоод, гадаадын байгууллагатай хамтран ажиллах;

4.2.3. Цус, цусан бүтээгдхүүний талаарх судалгааны ажил болон өөрийн байгууллагын гүйцэтгэсэн эрдэм шинжилгээний бүтээл, тайлан, технологийн заавар, судалгааны ажлын аргачлал боловсруулах, санал, дүгнэлт гаргах;

4.2.4. Төвийн лабораториуд нь мэргэжлийн чиглэлээр улсын хэмжээнд ажиллаж байгаа бусад холбох лабораториудаас хяналтын шинжилгээний сорьц авах, цусны албаны хэмжээнд дотоод, гадаад үнэлгээг эрхлэн хэрэгжүүлэх;

4.2.5. Цусны чиглэлээр олон улсын хурал, зөвлөгөөн, үзэсгэлэн яармаг зохион байгуулах, оролцох, өөрийн үйлдвэрийн бүтээгдэхүүнийг сурталчлах, мэдээлэл солилцох, туршлага судлах, зах зээл сонгох.

Тав. Хамтын ажиллагаа

5.1. Төвийн төсөв, санхүүжилттэй холбоотой үйл ажиллагаа нь Төсвийн тухай хууль болон бусад холбогдох хуулиар зохицуулагдана;


5.2. Төв нь хөдөлмөрийн гэрээний биелэлт, жилийн тайланг хууль журамд заасан хугацаанд Удирдах зөвлөлөөр хэлэлцүүлэн, дүгнүүлж Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ;

5.3. Төв нь урсгал санхүүжилт, хөрөнгө оруулалтын талаар тулгамдаж байгаа асуудлаар Удирдах зөвлөлөөр хэлэлцүүлэн Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүсэлт гаргаж, шийдвэрлүүлнэ;

5.4. Төв нь Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын холбогдох газар хэлтэстэй төлөвлөгөөний биелэлтийг жил бүр хэлэлцэж, үр дүнг тооцон, цаашид авах арга хэмжээг төлөвлөн, нягт хамтран ажиллана.



Лүс сэлбэлт судаллын үндэсний Төвийн бүтэц



ЦССҮТ-ийн орон тоо

1. Захирал-1
2. Дэд захирал -2
3. Захирлын ажлын алба - 4
 - Захирлын туслах, бичиг хэрэг, архивын ажилтан-1
 - Гадаад харилцааны ажилтан-1
 - Зөвлөх -1
 - Хуульч -1 /гэрээгээр/
4. Чанарын алба -3
 - Их эмч -1
 - Лаборант-1
 - Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер -1
5. Үндсэн чиг үүрэг бүхий үйл ажиллагааны алба-28

Донор элсүүлэх, цус, сийвэн цуглуулах тасаг-16

- Их эмч-4
- Нийгмийн ажилтан -1
- Сурталчилгаа хариуцсан сувилагч -1
- Технологич сувилагч –7
- Донорын бүртгэлийн ажилтан -1
- Хөтөч сувилагч- 1
- Мэдээллийн технологийн инженер-1

Технологийн тасаг- 12

- Их эмч-2
- Технологич сувилагч -6
- Жижүүрийн сувилагч -4

6. Нэгдсэн лабораторийн - 7

- Их эмч -3
- Лаборант-2 /5/
- Ариутгагч сувилагч -2

7. Стратеги төлөвлөлтийн алба - 19

Стратеги төлөвлөлт-2

- Хүний нөөцийн ажилтан – 1
- Статистикч, эдийн засагч -1

Сургалт, эрдэм шинжилгээний тасаг -2

- Эрдэм шинжилгээний ажилтан -1
- Сургалт, төслийн ажилтан - 1

Санхүү эдийн засаг -2

- Ерөнхий нягтлан бодох-1
- Тооцооны нягтлан бодох-1

Аж ахуйн тасаг -13

- Нярав -1
- Жолооч - 2
- Үйлчлэгч - 5
- Тогооч- 1
- Харуул -4 /гэрээгээр/

Нийт орон тоо - 64 /66/, үүнээс гэрээгээр - 5.